



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/381
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Хавдар судлалын үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M.

Ц.НАРАНЧИМЭГ

8/10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0224SAG58 Docx

УХА0122

070539



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Захиалагч:

УАГ-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:

Ц. Наранчимэг

өрөөний утас: 327744

Цахим хаяг:

naranchimegts@audit.gov.mn

УАГ-ын аудитын менежер

Я.Самбууням

өрөөний утас: 315558

Цахим хаяг:

sambuunyamy@audit.gov.mn

Аудитор:

Ж. Болормаа

Утас: 261628

Цахим хаяг:

bolormaa@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын газар

Байршил: Чингэлтэй дүүрэг,

Цахим хаяг

www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

“Аяа такс аудит” ХХК-ний Ерөнхий захирал

Я.Аюушжав

Утас: 99994447

И-мэйл: Ayaa_ayaab@yahoo.com

Аудитор: Ц. Хишигзаяа

Утас: 99087133

Хаяг: УБ хот, ЧД, 1-р хороо

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн
санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх
11. Аудитаар илрүүлсэн зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Зөрчилгүй санал дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд “Аяа такс аудит” ХХК гэрээний дагуу аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хавдар судлалын үндэсний төв нь 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 29-нөөс 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд завсрын болон гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөн “Аяа такс аудит” ХХК-ий аудитын баг хэрэгжүүлэв./ТАБ-СТА-А-9/

Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 20-нд “Аяа такс аудит” ХХК-нд ирүүлсэн байна.

“Аяа такс аудит” ХХК аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-оос 2017 оны 2 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 22-нд Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Ж.Чинбүрэнд гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хавдар судлалын үндэсний төв нь “Эрүүл мэндийн тухай”, “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “ Эрүүл мэндийн

байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлэгийн тусламж үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ” гэж эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог тодорхойлсоны дагуу Хавдар судлалын үндэсний төв үйл ажиллагаагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хавдар Судлалын Үндэсний Төвийн эрхэм зорилго нь үндэсний хэмжээнд хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг чанартай, ээлтэй болон тэгш хүртээмжтэй хүргэхэд оршино гэж тодорхойлон ажиллаж байна.

Тус төв нь технологийн дэвшил, мэс заслын эмчилгээ, элэгний хавдрыг сэргээн засах, дүрс оношлогоо, аюулгүй ажиллагааны стандарт, 24 цагийн лаборатори, 21 аймаг, 9 дүүргийн хими туяа эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж байгаа дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 20-ийг гүйцэтгэв. ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хавдар судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан тус төвийн захирлын 170 дугаар тушаалаар батлуулан 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцэж байна.

Хавдар судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, программд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Хавдар судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “ACOLOUS” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Материаллаг байдал:

Хавдар судлалын үндэсний төв төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатанд материалаг байдлыг 2016 оны төсвийн зарлагын хэмжээг материаллаг байдлын суурь болгон авч 1 хувиар сонгон 166,9 сая төгрөгөөр тогтоов. /ТАБ-СТА-А-4/, ТАБ-СТА-В-1/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан.

Тус эмнэлэгийн дотоод хяналтын хүрээнд дараахь ажлыг хийсэн байна. Үүнд:

Дотоод аудитаар тендерийн баримт бичиг, тендерийн үнэлгээнд эрсдлийн үнэлгээ хийх, жижиг мөнгөн сан, касс, харилцахын анхан шатны баримтын бүрдүүлэлтэд шалгалт хийж хяналтыг сайжруулах үүрэг өгсөн байна.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хавдар судлалын үндэсний төвийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хавдар судлалын үндэсний төвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 8,683.7 сая төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас 4,053.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1,214.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 182,3 сая төгрөг, бусад орлогоор 454,3 сая

төгрөг, нэмэлт санхүүжилтээр 580,0 сая төгрөг нийт 15,168.1 сая төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Тайлант хугацаанд бараа ажил үйлчилгээний урсгал зардал 14,875.1 сая төгрөг, засгийн газрын дотоод шилжүүлгээр 122,8 сая төгрөг, тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж 170,6 сая төгрөг нийт 15,168.4 сая төгрөгийн төсвийн зарлагын гүйцэтгэл гарсан байна.

8. Шилэн дансны мэдээлэл:

Хавдар судлалын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэлийн 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаа, бусад зарлагын гүйлгээний мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулж байна.

Тайлант онд шилэн дансны хэрэгжилтийг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас 2 удаа шалгаж зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:

Төлөвлөлтийн үе шатанд аудитын 3 чиглэлээр 39 эрсдлүүдийг тогтоон түүнд тавигдах хяналтуудыг үнэлэхэд үр нөлөөтэй байгаа тул нарийвчилсан сорилын аргаар даган мөшгих сорилыг хийлээ.

Санхүүгийн аудитыг төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 3 ажилбараар тус тус харуулав.

Үйлчлүүлэгчээс авсан тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтууд болон өөрсдийн хийсэн судалгаануудыг байгууллагын хард дискэнд хадгалав.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

Үндсэн үйл ажиллагааны орлого 420,4 сая төгрөгөөр буюу 76,9 хувиар тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “ хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь оношлогооны компьютер томографын аппарат ашиглалтанд ороогүй, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 07 тоот тогтоолын дагуу тус байгууллагад өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэлээр тайлант оны 3 дугаар улирал (9 дүгээр сар)-аас хангаж эхэлсэн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг мөрдөж төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах. Төлөвлөлтийг бодит байдалд нийцүүлэхэд анхаарах.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа үгүй болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Австри улсын засгийн газрын хөнгөлөлттэй 6,35 сая евро буюу Монгол банкны ханшаар 16,546.8 сая төгрөгийн зээлээр эмнэлэгийн тоног төхөөрөмжүүд тус эмнэлэгт нийлүүлэгдсэн боловч өргөтгөлийн барилга бүрэн ашиглалтанд ороогүйгээс тоног төхөөрөмжүүдийн суурилуулалт хойшлогдсоноор агуулахад 2 жил хадгалагдаж бүртгэлт тусгаагүй нь Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн 148 дугаар тогтоолын 1а-д “улсын төсвийн санхүүжилтээр бий болгосон болон гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс Монгол Улсын Засгийн газарт зориулж хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тоолж үнэлсний үндсэн дээр эзэмших этгээдийг тогтоож, бүртгэлд тусгаж байх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй;

Дараагийн санхүүгийн аудитаар Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 415 дугаар тушаалын 6 дугаар зүйл “тайлагнах”-ийн 6.1-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусгах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана гэсний дагуу гүйцээж мөшгин шалгах.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хавдар судлалын үндэсний төв 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 420,4 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар санхүүгийн тайланд зөвлөмж өглөө.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Хавдар судлалын үндэсний төвийн 2015 оны санхүүгийн тайланд 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 33,3 хувьтай байна. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн талаар дараахь тайлбарыг өгч байна. Үүнд:

1. Эмнэлэгийн барилга бүрэн ашиглалтанд ороогүй, тоног төхөөрөмжийн суурилалт хийгдээгүйн улмаас захиалагч Эрүүл мэндийн яам тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тус төвд хүлээлгэн өгөх ажил хийгдээгүй;
2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор хорт хавдрын зарим тусламж үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх үлдэх хэсгийг үйлчлүүлэгч иргэдээс авахаар заагдсан боловч иргэдээс орох орлого төлбөрт үйлчилгээний орлого ороогүй учир биелээгүй;

17. Зөвлөмж

Хавдар судлалын үндэсний төвийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөв.

18. Зөрчилгүй санал дүгнэлт:

Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, менежментийн захидал 14 хуудсыг тус тус хавсаргав.



**ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1.

Үндсэн хөрөнгө

Асуудал 2.

Орлого

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтануудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Орлого	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 420,4 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “ хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухай байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг мөрдөж төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах. Төлөвлөлтийг бодит байдалд нийцүүлэхэд анхаарах.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтануудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Эрсдэлүүд:

Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс улс орон нутгийн төсөвт орох орлогын хэмжээ буурах.

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ДАНС	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,055,664,652.75	1,743,205,837.79
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	300,000.00	
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	300,000.00	-
31110	Төгрөг	300,000.00	-
33	АВЛАГА	160,000.00	201,572,299.42
335	Бусад авлага	160,000.00	201,572,299.42
3351	Байгууллагаас авах авлага	160,000.00	201,572,299.42
35	БАРАА МАТЕРИАЛ	1,055,204,652.75	1,541,633,538.37
351	Түүхий эд материал	462,177,644.06	752,006,949.13
35130	Эм боох материал	462,177,644.06	752,006,949.13
354	Хангамжийн материал	593,027,008.69	789,626,589.24
35410	Бичиг хэргийн материал	845,700.00	1,323,280.00
35420	Аж ахуйн материал	26,924,000.00	26,924,000.00
35450	Барилгын засварын материал	6,176,150.00	2,982,730.00
35460	Хүнсний материал	8,078,000.00	24,063,015.00
35470	Бусад хангамжийн материал	551,003,158.69	734,333,564.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,537,250,148.28	14,106,548,300.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,537,250,148.28	14,106,548,300.51
392	Биет хөрөнгө	17,472,964,014.76	14,073,268,866.95
39201	Барилга, байгууламж	12,903,383,040.10	12,903,383,040.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,107,966,478.13)	(7,353,219,715.61)
39203	Авто тээврийн хэрэгсэл	312,862,000.00	312,862,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(170,895,638.96)	(213,111,305.76)
39205	Машин, тоног төхөөрөмж	15,493,360,295.16	17,848,623,888.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,280,520,751.92)	(9,867,784,789.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	551,325,558.79	749,772,586.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(343,837,555.51)	(396,266,825.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	243,891,594.31	246,741,594.31
39215	Хуримтлагдсан элэгдэл	(141,866,880.08)	(157,731,605.46)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	4,013,228,831.00	-
393	Биет бус хөрөнгө		

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

		64,286,133.52	33,279,433.56
39301	Програм хангамж	227,648,595.00	202,171,939.00
39302	Хасагдуулга	(163,362,461.48)	(168,892,505.44)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,592,914,801.03	15,849,754,138.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	18,592,914,801.03	15,849,754,138.30
51	Засгийн газрын хувь оролцоо	18,592,914,801.03	15,849,754,138.30
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	17,025,450,888.38	17,025,450,888.38
51101	Өмч: -Төрийн өмч	17,025,450,888.38	17,025,450,888.38
512	Хуримтлагдсан үр дүн	(3,191,924,055.39)	(5,935,084,718.10)
51210	Өмнөх үеийн үр дүн	(6,008,229,975.76)	(7,205,152,886.39)
51220	Тайлант үеийн үр дүн	2,816,305,920.37	1,270,068,168.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,759,387,968.04	4,759,387,968.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	18,592,914,801.03	15,849,754,138.30

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,388,960,916.55	17,964,898,312.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,066,494,811.49	3,699,787,066.72
120	Нийтлэг татварын бус орлого	1,930,922,387.49	2,583,006,443.72
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,383,332,534.49	2,128,870,135.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,124,125,269.00	1,214,042,035.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	166,926,838.60	189,391,927.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	92,280,426.89	725,436,173.30
120009	Бусад орлого	547,589,853.00	454,136,308.42
122	Тусламжийн орлого	1,135,572,424.00	1,116,780,623.00
12200202	Хөрөнгийн хандив/гадаад/	1,135,572,424.00	1,116,780,623.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,322,466,105.06	14,265,111,245.77
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,076,263,638.00	8,683,699,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,076,263,638.00	8,683,699,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,997,502,467.06	1,527,610,659.77
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	2,744,692,471.81	3,725,149.77
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	943,885,510.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	6,462,500.00	580,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	246,347,495.25	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	1,248,700,000.00	4,053,801,086.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	1,248,700,000.00	4,053,801,086.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	13,541,935,784.26	16,694,929,708.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,453,545,120.92	16,477,289,203.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,453,545,120.92	16,477,289,203.49
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,126,174,765.92	5,346,787,956.00
210101	Цалин	5,027,859,427.92	5,325,727,956.00
210104	Урамшуулал	19,700,000.00	4,535,000.00
210105	Гэрээтийн цалин	78,615,338.00	16,525,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	602,032,800.00	635,610,729.69
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	354,110,837.00	373,746,996.14
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	40,486,037.00	42,728,159.62
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	99,825,013.00	105,415,305.04
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	9,782,810.00	10,338,204.99
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	97,828,103.00	103,382,063.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	329,239,366.34	368,576,688.00
210301	Гэрэл цахилгааны зардал	134,692,552.00	166,599,177.00
210302	Түлш, халаалтын зардал	97,454,804.00	116,087,457.00
210303	Цэвэр, бохир усны зардал	97,092,010.34	85,890,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	303,812,190.93	346,684,791.64
210401	Бичиг хэргийн материал	56,796,315.00	66,214,495.00
210402	Тээвэр, шатахууны зардал	42,829,760.00	49,416,050.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	11,607,196.93	8,940,085.64

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

210404	Ном, хэвлэлийн зардал	1,664,450.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	21,618,383.00	25,044,100.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,099,660.00	3,118,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	168,196,426.00	193,951,461.00
2105	Нормативт зардал	5,033,432,239.88	5,826,368,446.66
210502	Хоол	420,460,120.00	449,128,546.35
210501	Эм	4,612,972,119.88	5,377,239,900.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,039,762.00	109,337,899.19
210601	Багаж хэрэгсэл	4,216,951.00	379,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,920,000.00	1,706,460.00
210604	Урсгал засвар	164,902,811.00	107,251,539.19
2107	Томилолт, зочны зардал	48,707,660.00	58,026,040.00
210701	Гадаад томилолтын зардал	10,188,800.00	10,248,500.00
210702	Дотоод томилолтын зардал	38,518,860.00	47,777,540.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	21,101,950.00	63,534,128.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	34,195,418.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,000,000.00	2,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	350,000.00	68,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	85,000.00	71,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,784,250.00	6,880,440.00
210807	Газрын төлбөр	2,250,000.00	3,652,000.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	11,232,700.00	15,366,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,818,004,385.85	3,722,362,524.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,365,007.57	1,218,183,543.19
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	36,027,965.00	54,715,570.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,657,611,413.28	2,449,463,411.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,390,663.34	217,640,504.87
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,161,631.34	47,077,204.87
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,161,631.34	47,077,204.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,229,032.00	170,563,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,699,024.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,530,008.00	170,563,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	2,847,025,132.29	1,269,968,604.13
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	1,389.45	99,564.15
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,389.45	99,564.15
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	30,720,601.37	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	30,720,601.37	0.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(30,719,211.92)	99,564.15
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	2,816,305,920.37	1,270,068,168.29

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
№	ДАНС	511	51300	51210+51220	
1	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	17,025,450,888.38	4,762,716,320.09	(6,011,558,327.81)	15,776,608,880.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,328,352.05	3,328,352.05
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,025,450,888.38	4,762,716,320.09	(6,008,229,975.76)	15,779,937,232.71
4	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	(3,328,352.05)	-	(3,328,352.05)
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	
7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		-	2,816,305,920.37	2,816,305,920.37
8	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	17,025,450,888.38	4,759,387,968.04	(3,191,924,055.39)	18,592,914,801.03
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(4,013,228,831.00)	(4,013,228,831.00)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,025,450,888.38	4,759,387,968.02	(7,205,152,886.39)	14,579,685,970.01
11	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-		-	
12	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	
14	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		-	1,270,068,168.29	1,270,068,168.29
15	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	17,025,450,888.38	4,759,387,968.02	(5,935,084,718.10)	15,849,754,138.30

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-3А

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,973,147,699.00	15,168,135,219.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,648,184,061.00	1,850,634,633.42
120	Нийтлэг татварын бус орлого	1,648,184,061.00	1,850,634,633.42
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,268,064,126.60	1,396,338,325.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,124,125,269.00	1,214,043,794.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,938,857.60	182,294,531.00
120009	Бусад орлого	380,119,934.40	454,296,308.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,324,963,638.00	13,317,500,586.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,076,263,638.00	8,683,699,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,076,263,638.00	8,683,699,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	580,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	580,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,248,700,000.00	4,053,801,086.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжих	1,248,700,000.00	4,053,801,086.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	11,862,220,699.00	14,762,299,191.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,862,220,699.00	14,762,299,191.42
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,772,173,159.74	14,468,957,923.13
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4,935,455,560.00	5,176,526,593.80
210101	Үндсэн цалин	3,881,371,659.40	4,097,952,222.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	407,922,800.00	436,434,800.00
210104	Үр дүнгийн урамшуулал	514,293,100.00	510,271,571.80
210105	Гэрээт ажлын хөлс	131,868,000.60	131,868,000.00
2102	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	594,117,200.00	615,528,800.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	594,117,200.00	615,528,800.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	329,239,366.34	368,576,688.00
210301	Гэрэл цахилгааны зардал	134,692,552.00	166,599,177.00
210302	Түлш, халаалтын зардал	97,454,804.00	116,087,457.00
210303	Цэвэр, бохир усны зардал	97,092,010.34	85,890,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	221,419,429.93	251,855,815.64
210401	Бичиг хэрэг	19,470,780.00	12,085,000.00
210402	Тээвэр, шатахуун	41,549,650.00	48,948,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,742,096.93	9,111,285.64
210404	Ном, хэвлэл	4,657,150.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	129,987,783.00	141,032,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,011,970.00	40,678,380.00
2105	Нормативт зардал	5,185,930,855.47	6,223,253,783.51
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,682,461,457.47	5,698,515,228.51
210502	Хоол, хүнс	447,619,698.00	469,896,955.00

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	55,849,700.00	54,841,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,984,285.00	334,710,007.00
210601	Багаж техник хэрэгсэл	33,886,511.00	217,805,905.00
210602	Тавилга	1,402,500.00	53,887,795.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	11,574,000.00	23,397,671.00
210604	Урсгал засвар	41,121,274.00	39,618,636.00
2107	Томилолт, зочны зардал	48,707,660.00	58,026,040.00
210701	Гадаад албан томилолт	10,188,800.00	10,248,500.00
210701	Дотоод албан томилолт	38,518,860.00	47,777,540.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,449,070.00	65,031,958.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	34,195,418.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	68,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	71,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,364,070.00	6,880,440.00
210807	Газрын төлбөр	2,250,000.00	3,652,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	16,864,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	355,869,733.00	1,375,448,237.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	313,241,448.00	1,311,874,567.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	42,628,285.00	63,573,670.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,047,539.26	293,341,268.29
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,321,631.34	122,777,968.29
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,321,631.34	122,777,968.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,725,907.92	170,563,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,195,899.92	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,530,008.00	170,563,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	110,927,000.00	405,836,028.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	(110,627,000.00)	(406,136,028.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	(110,627,000.00)	(406,136,028.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	(110,627,000.00)	(406,136,028.00)
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	(110,627,000.00)	(406,136,028.00)
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(110,627,000.00)	(406,136,028.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	300,000.00	(300,000.00)
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	300,000.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	300,000.00	(300,000.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,001,910,100.00	15,168,435,219.42	(166,525,119.42)	101.1
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	15,001,910,100.00	15,168,435,219.42	(166,525,119.42)	101.1
210	Бараа, үйлчилгээний зардал	14,831,346,800.00	14,875,093,951.13	(43,747,151.13)	100.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,129,408,100.00	5,176,526,593.80	(47,118,493.80)	100.9
210101	Үндсэн цалин	4,050,413,700.00	4,097,952,222.00	(47,538,522.00)	101.2
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	436,434,800.00	436,434,800.00	-	100.0
210104	Урамшуулал	510,691,600.00	510,271,571.80	420,028.20	99.9
210105	Гэрээт ажлын хөлс	131,868,000.00	131,868,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	615,528,800.00	615,528,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	615,528,800.00	615,528,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	456,300,900.00	368,576,688.00	87,724,212.00	80.8
210301	Гэрэл цахилгаан	156,820,700.00	166,599,177.00	(9,778,477.00)	106.2
210302	Түлш, халаалт	193,026,200.00	116,087,457.00	76,938,743.00	60.1
210303	Цэвэр, бохир ус	106,454,000.00	85,890,054.00	20,563,946.00	80.7
2104	Хангамж, бараа материалын зардал	213,829,700.00	253,881,715.64	(40,052,015.64)	118.7
210401	Бичиг хэрэг	5,625,800.00	13,831,000.00	(8,205,200.00)	245.8
210402	Тээвэр (шатахуун)	18,030,300.00	48,948,450.00	(30,918,150.00)	271.5
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	9,400,000.00	9,111,285.64	288,714.36	96.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	141,032,700.00	141,032,700.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	39,740,900.00	40,958,280.00	(1,217,380.00)	103.1
2105	Нормативт зардал	6,327,274,600.00	6,231,307,583.51	95,967,016.49	98.5
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	5,802,604,100.00	5,706,569,028.51	96,035,071.49	98.3
210502	Хоол, хүнс	469,540,500.00	469,896,955.00	(356,455.00)	100.1
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	55,130,000.00	54,841,600.00	288,400.00	99.5

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2106	Эд хогшил худалдан авах	72,945,300.00	725,081,335.00	(652,136,035.00)	994.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,396,300.00	584,823,699.00	(562,427,399.00)	2,611.3
210602	Тавилга	2,219,500.00	73,555,795.00	(71,336,295.00)	3,314.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	26,268,500.00	26,698,205.00	(429,705.00)	101.6
210604	Урсгал засвар	22,061,000.00	40,003,636.00	(17,942,636.00)	181.3
2107	Томилолт, зочны зардал	3,963,700.00	58,026,040.00	(54,062,340.00)	1,463.9
210701	Гадаад албан томилолт	-	10,248,500.00	(10,248,500.00)	
210702	Дотоод албан томилолт	3,963,700.00	47,777,540.00	(43,813,840.00)	1,205.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	71,158,700.00	65,031,958.00	6,126,742.00	91.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,000,000.00	34,195,418.00	1,804,582.00	95.0
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	6,600,000.00	2,900,000.00	3,700,000.00	43.9
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	68,400.00	281,600.00	19.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	85,000.00	71,500.00	13,500.00	84.1
210806	Мэдээллийн технологийн зардал	6,900,000.00	6,880,440.00	19,560.00	99.7
210807	Газрын төлбөр	4,000,000.00	3,652,000.00	348,000.00	91.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,823,700.00	-	16,823,700.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	16,864,200.00	(16,864,200.00)	
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,940,937,000.00	1,381,133,237.18	559,803,762.82	71.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,940,937,000.00	1,317,559,567.18	623,377,432.82	67.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	63,573,670.00	(63,573,670.00)	
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,563,300.00	293,341,268.29	(122,777,968.29)	172.0
2131	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	122,777,968.29	(122,777,968.29)	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	122,777,968.29	(122,777,968.29)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	170,563,300.00	170,563,300.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	170,563,300.00	170,563,300.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,001,910,100.00	15,168,135,219.42	(166,225,119.42)	101.1

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,720,157,700.00	8,683,699,500.00	36,458,200.00	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,720,157,700.00	8,683,699,500.00	36,458,200.00	99.6
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,465,018,000.00	4,053,801,086.00	411,216,914.00	90.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,465,018,000.00	-	4,465,018,000.00	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох	-	4,053,801,086.00	(4,053,801,086.00)	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,816,734,400.00	1,850,634,633.42	(33,900,233.42)	101.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	220,000,000.00	182,294,531.00	37,705,469.00	82.9
1200041	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,596,734,400.00	1,214,043,794.00	382,690,606.00	76.0
1200044	Бусад орлого	-	454,296,308.42	(454,296,308.42)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	580,000,000.00	(580,000,000.00)	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	580,000,000.00	(580,000,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	300,000.00	(300,000.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	489.00	489.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	335.00	335.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	146.00	146.00	-	100.0
620004	Гэрээт ажилтан	7.00	7.00	-	100.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	108,054.00	112,195.00	(4,141.00)	103.8
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	10,286.00	10,255.00	31.00	99.7
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	97,768.00	101,940.00	(4,172.00)	104.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	489	489	-	
650001	Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	1	1	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/	343	343	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	138	138	-	100.0
650010	Гэрээт ажилтан				

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

		7	7	-	100.0
--	--	---	---	---	-------